

ОРОСЫН ЦАГААН ХААНЫ ОРДОНЫ ЭМЧ П.А.БАДМАЕВЫН ТУХАЙ НОМ ГАРЛАА

*О.Батсайхан**

Түүх судлаач Ю.В.Кузьмин «П.А.Бадмаев: дипломат, политик, предприниматель Байкальский государственный университет экономики и права Иркутск., Издательство БГУЭП, 2002, - 108 с.» эл бүтээлээрээ хувь хүний намтар судлалыг маш өвөрмөц онцлог бүхий бичлэгийн хэлбэрээр чадварлаг харуулж болохыг үзүүлжээ.

Монгол овогтоноос уг гарвалтай, Оросын их гүрний түүхэнд нэрээ үлдээсэн, сонирхол татахуйц нэгэн буриад хөвүүн бол эдүгээгийн Оросын буриадын Агийн нутагт төрж, Хаант Орос улсын төрийн Дорнодахинд чиглэсэн гадаад бодлогод өөрийн санал бодлоо уралдуулж, хэрэгжүүлэхийг оролдсон, Эзэн хааны ордонд эзэлсэн тодорхой байр суурьтай болж чадсан Петр Михайлович Бадмаев ажээ.

Түвдийн анагаах ухааныг эзэмшсэн энэ хүний тухай үнэн худал нь үл мэдэгдэх мэдээ, мэдээлэл цөөнгүй гарсан боловч ОХУ-ын Эрхүү хотын Байгалийн эдийн засаг, эрх зүйн их сургуулийн багш, монгол судлаач, доктор, профессор Ю.В.Кузьмины бичсэн эл ном нь П.А.Бадмаевын олон талт үйл ажиллагаанд архив, түүхийн эх сурвалжид тулгуурлан шинжлэх ухааны дүн шинжилгээ өгөхийг оролдсон судалгааны дорвитой зохиол болжээ.

Ю.В.Кузьмины энэ бүтээл Түвдийн анагаах ухааны эмч, Оросын дипломатч, худалдаа- үйлдвэрлэлийн эзэн, хувийн сонины эрхлэгч, маш их ээдрээтэй, зөрчил бүхий амьдрал туулсан П.А.Бадмаевын бүхий л талын үйл ажиллагааг харуулснаас гадна Орос их гүрний Х1Х зууны сүүл, ХХ зууны эхэн үед Дорнодахин, түүний дотор Монгол, Түвд, Хятадын талаар баримталж байсан бодлогыг зарим талаар хөндөж чадсанаараа өвөрмөц онцлогтой байна.

Тэрээр П.Бадмаевын үйл ажиллагааны талаар урьд өмнө нийтлэгдэж байсан Оросын түүх бичлэг дэхь зөрчилт дүгнэлт, санаа бодролуудыг ялган салгаж, түүний олон талт үйл ажиллагааны тодорхой бус хийгээд бага судлагдсан талуудыг Оросын их гүрний гадаад бодлогын архив, Эрхүүгийн сан хөмрөгүүдээс олдсон ховор сурвалжуудад тулгуурлан судалжээ.

*О.Батсайхан – ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

Дорнодахин дахь Оросын эзэнт гүрний геополитикийн ашиг сонирхлын талаар генерал – губернатор Н.Н.Муравьев – Амурский нарын зэрэг хүмүүс өөрсдийн санал бодлоо илэрхийлж, хэрэгжүүлэхийг зорьж байсан байдаг билээ. Харин тэдний дэвшүүлсэн далд санааг ил болгон Дорнодахин руу Орос орны хүрээг тэлж, түүнд Монгол, Түвд, Хятадын хэсгийг хойш тавилгүй нийлүүлэх тухай төслийг П.А.Бадмаев боловсруулсан нь Оросын хаан хоёрдугаар Николайд таалагдаж, улмаар энэ төслөө хэрэгжүүлэх үүднээс Хааны шууд дэмжлэгтэйгээр 2 сая рублийн (тэр үеийн ханшаар энэ бол дэндүү их мөнгө) зээл аван «Бадмаев ба К» гэсэн худалдааны компани байгуулж, худалдаа, үйлдвэрлэл, шашины талаар хэрхэн үйл ажиллагаа явуулсаныг түүхэн баримт, эх сурвалжид тулгуурлан зохиогч дэлгэн тавьжээ.

Бадмаев өөрийн үйл ажиллагаагаа дэлгэрүүлэх, дэмжлэг авах үүднээс «Жизнь на восточной окраине» (Дорнод хязгаар дахь амьдрал) нэртэй сониныг Чита хотод эрхлэн орос, монгол хэл дээр 1896-1897 онуудад 100 гаруй дугаар гаргаж байсаныг тодорхой харуулжээ.

Түвдийн анагаахын эмч, үнэн алдартаны шажинтан, Петербургт бурханы шашины сүм барихыг дэмжигч, Оросын их гүрний хаан, түүний гэр бүл, төрийн томоохон зүтгэлтнүүдтэй сүлбэлдэгч, төрийн дипломатч, улс төрч, үйлдэрийн эзэн, худалдаачин, хувийн сонины эрхлэгч гэх мэт олон нэрийг урдаа зүүсэн, нууцлаг тал ихтэй монгол цусны Бадамын Жамсран буюу Петр Александрович Бадмаевын нууцлаг амьдрал, үйл ажиллагааны талаар нилээд зэхэлтэй мэдээлэл, баримтуудыг Ю.В.Кузьмины судалгааны эл бүтээлээс уншигч та олж харах болно.

Уг номын бүтэцийг толилуулваас,

- П.А.Бадмаевын намтар дахь цагаан толбо
- Түвдийн анагаахын доктор П.А.Бадмаевын үйл ажиллагааг тодорхойлсон хоёр хандлага
- П.А.Бадмаевын хувийн болон бусад үйл ажиллагааны талаарх дурдатгалууд
- Петр Александрович Бадмаев хэзээ төрсөн бэ
- Жамсрангийн хүүхэд ба залуу нас. Хувь хүний төлөвшилт
- Жамсран үнэн алдартны шашинд орж, П.А.Бадмаев болсон нь
- Түвдийн анагаах ухаанд суралцсан нь: П.А.Бадмаев ба Н.В.Кирилов

- Түвдийн анагаахын доктор П.А.Бадмаевын Забайкалье ба Монгол дахь үйлдвэрийн эзний үйл ажиллагаа
- «Дорнод хязгаарын амьдрал» - монгол хэл дээрх анхны сонин
- П.А.Бадмаевын хэвлэн нийтлэгчийн үйл ажиллагаа
- Бадмаев ба Г.Распутин Хувьсгалын өмнөх Оросын улс төрийн амьдралд П.А.Бадмаевын оруулсан роль
- Дүгнэлт гэсэн хэсгүүдээс бүрдсэн байна.

Мөн эдгээрээс гадна П.А.Бадмаевын намтрын хэлхээс, бүтээлийн жагсаалтыг хавсаргасан байна.

Ю.В.Кузьмины энэхүү зохиолд Оросын их гүрний Дорнодахинд чиглэсэн геополитикийн талаар дутмаг өгүүлжээ хэмээн бодогдлоо. Магадгүй энэ талаарх баримт бичгүүд хийгээд П.А.Бадмаевын улс төрийн зарим үйл ажиллагаанд холбогдох баримт бичгүүд өнөө хүртэл нууцлаг байдалд үлдсэн байхыг зохиогч үгүйсгээгүй байна.

Уг бүтээлд уг үсгийн чанартай зарим нэг алдаа байгааг эс тооцвол энэ ном нь түүхийн шинжлэх ухаанд өөрийн хувь нэмрийг оруулсан судалгааны дорвитой бүтээл болжээ.